



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот


Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх ажлын удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081191

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 04 өдрийн
33 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

Ажлын удирдамж

Зорилго:

2010-2021 онд хэрэгжүүлэх “Эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийж, санал зөвлөмж боловсруулахад оршино.

Үнэлгээний хамрах хүрээ:

1. Хүн амын өвчлөлд нөлөөлөх эрсдэлт зан үйлийг өөрчлөх;
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх;
3. Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй хангах;
4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлж, байгууллагын хөгжил, салбарын удирдлагын тогтолцоог цогцоор нь хөгжүүлэх;
5. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, төсвийн санхүүжилтийн хувь хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтуудын хэрэгжилт, үр дүнг тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэл:

- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэнэ.
- Хөтөлбөрийн зорилт тус бүрээр ололт амжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон үр дүнг тооцож, шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх арга замыг тусгасан тодорхой зөвлөмжүүд дэвшүүлнэ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилтийг тооцно.
- Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсэх талаар үндэслэл бүхий санал дэвшүүлнэ.
- Үнэлгээний тайланг эцэслэн ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.


Хугацаа:

2015 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 30-ны өдрийг дуустал

Хүрэх үр дүн:

- Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, санал зөвлөмж дэвшүүлсэн байна.
- Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсэх асуудлыг Удирдлагын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн байна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09.. сарын 04. өдрийн
345 дугаар тушаалын 2 дугаар
хаворалт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ахлагч: Э.Оюунсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Гишүүд: Б.Хонгорзул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн
- Г.Туул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн
- Н.Оюунгэрэл, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
- С.Гончигсумлаа, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
- Д.Оюунтуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн
- С.Отгонсүх, Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн мэргэжилтэн
- Д.Уранчимэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны дарга
- Л.Төмөрбаатар, Эрүүл мэнд спортын яамны Эрүүл мэндийн удирдлагын ерөнхий мэргэжилтэн
- Д.Энхжаргал, Эрүүл мэнд спортын яамны Эм зүй, эм судлалын ерөнхий мэргэжилтэн